



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 193

Улаанбаатар хот

“Увс АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, контрактын биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Увс АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Гүйцэтгэх захирал Ц.Цэдэнбалтай байгуулсан контрактын биелэлтийг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001678